



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 4/01

Хархорин сум

Цалингийн санг шинэчлэн
тогтоох тухай

Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2.3, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.1, 57.2.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2007 оны “Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 73 дугаар тогтоолын 1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын 1, 4 дүгээр хавсралт болон 6 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ын 4, 5 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолын 3, 11 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын улс төрийн болон төрийн захиргааны албан хаагчдын цалингийн санг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.Батлагдсан цалингийн санд багтаан албан хаагчдын цалинг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн бодож олгохыг нягтлан бодогч (Г.Оюун)-д зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2023 оны Б/01 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ОДГЭРЭЛ

401100022

Хархорин сумын Засаг даргын 2024 оны
а. дүгээр сарын 08-ны өдрийн А.О.
дугаар захирамжийн хавсралт

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН УЛС ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН
ХААГЧДЫН ЦАЛИНГИЙН САН

д/д	Овог нэр	Албан тушаал	Ангилал, зэрэглэл	Албан тушаалын цалин	Төрийн албан хаасан хугацааны нэмэгдэл (хувь)	Зэрэг дэвийн нэмэгдэл (хувь)	Орон нутгийн нэмэгдэл (хувь)	Онцгой нөхцлийн нэмэгдэл /Цолны/ (хувь)	Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл (хувь)	Нууц хамгаалалтын ажиглалтын нэмэгдэл (хувь)	Хоолны хөнгөлөлт
1	Б.Лхагвасүрэн	Засаг даргын орлогч	УТ	1,700,000	-	-	-	30	-	-	10,000
2	Т.Алтангэрэл	Багийн Засаг дарга	УТ	1,250,000	-	-	-	30	-	-	10,000
3	Р.Сүхбат	Багийн Засаг дарга	УТ	1,250,000	-	-	-	30	-	-	10,000
4	Д.Батчулуун	Багийн Засаг дарга	УТ	1,250,000	-	-	-	30	-	-	10,000
5	Г.Отгонбаяр	Багийн Засаг дарга	УТ	1,250,000	-	-	-	30	-	-	10,000
6	Б.Ганхуяг	Багийн Засаг дарга	УТ	1,250,000	-	-	-	30	-	-	10,000
7	Л.Төгөлдөр	Багийн Засаг дарга	УТ	1,250,000	-	-	-	30	-	-	10,000
8	О.Батсүх	Багийн Засаг дарга	УТ	1,250,000	-	-	-	30	-	-	10,000
9	П.Нэндарам	Багийн Засаг дарга	УТ	1,250,000	-	-	-	30	-	-	10,000

10	Х.Лхагвадулам	Засаг даргын Тамгын газрын дарга	ТЗ-5	1,597,000	25	24	40	-	30	20	10,000
11	Ц.Мягмарсүрэн	Санхүүгийн албаны дарга	ТЗ-7	1,320,000	2	-	40	5	-	-	10,000

--oOo--